



**Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлж буй иргэдээс
авсан 2023 оны 10,11 саруудын сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл**

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс хүлээж буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын түүвэр судалгааны аргыг ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ


- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний А заал 101 тоотоос иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.

Жич: Сэтгэл ханамжийн судалгаа нь 10 сард шинэчлэн ирсэн тиймээс 10,11 саруудыг хамт дүгнэсэн.

СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Зураг1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн хүйс



Дүгнэлт: Орхон аймаг Нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс 10,11 саруудын сэтгэл ханамжийн судалгаанд 346 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 278 иргэн буюу 80.3 % эмэгтэй, 68 иргэн буюу 19.7% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.


Хүснэгт1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал

	Иргэдийн тоо	Хувь
Таны нас	20 хүртэл	22 6.4%
	20-29	98 28.3%
	30-39	9 2.6%
	40-49	85 24.6%
	50-59	4 1.2%
	60-аас дээш	14 4.0%
Нийт үр дүн	346	100%

Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн насны хувьд авч үзвэл 20 хүртэлх насны 22 иргэн буюу 6.4% , 20-29 насны 98 иргэн буюу 28.3% , 40-49 насны 85 иргэн буюу 24.6% , 50-59 насны 4 иргэн буюу 1.2%, 60-аас дээш насны 14 иргэн буюу 4.0% тус бүрийн тоон үзүүлэлтүүд гарсан байна.



График1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээний төрөл



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 346 иргэдийн тэтгэвэртэй холбоотой үйлчилгээг 10 сард 23 иргэн, 11 сард 20 иргэн тус бүр авсан бол тэтгэмжтэй холбоотой 10 сард 3 иргэн, 11 сард 16 иргэн, сайн дурын даатгалын үйлчилгээтэй холбоотой 10 сард 19 иргэн, 11 сард 14 иргэн, нийгмийн даатгалын шимтгэл талаар 10 сард 17 иргэн, 11 сард 68 иргэн, зөвлөгөө мэдээлэл 10 сард 12 иргэн, 11 сард 68 иргэн, бусад үйлчилгээ дээр 10,11 саруудад тус бүр 29 иргэн үйлчилгээ авсан байна.


Хүснэгт2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ шуурхай, хялбар

		Иргэдийн тоо	
		10 сард	11 сард
Нийгмийн даатгалын байгууллага үйлчилгээ шуурхай, хялбар байсан уу?	Маш сайн	36	111
	Сайн	63	108
	Дунд	4	24
	Муу	-	-
	Маш муу	-	-
Нийт үр дүн		346	

Дүгнэлт: Судалгаанд оролцсон 346 иргэдийн маш сайн үнэлгээг 10 сард 36 иргэн, 11 сард 111 иргэн, сайн үнэлгээг 10 сард 63 иргэн, 11 сард 108 иргэн, дунд үнэлгээг 10 сард 4 иргэн, 11 сард 24 иргэн, муу болон маш муу үнэлгээг сонгоогүй нь нийгмийн даатгалын үйлчилгээ хялбар, түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж байна.




Зураг2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл авсан үнэлгээ



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн “Тийм” гэсэн үнэлгээг 338 иргэн буюу (97.7%), “Үгүй” гэсэн үнэлгээг 8 иргэн буюу (2.3%) тус бүр өгсөн байна.

График2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн зөвлөгөө, ажилтны харилцаа, хандлага үнэлгээ




Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн сэтгэл ханамжтай 321 иргэн буюу (92.8%), сэтгэл дундуур 25 иргэн (7.2%), сэтгэл ханамжгүй үнэлгээг сонгоогүй. Үүнд: “Сэтгэл ханамж өндөр үзүүлэлттэй гарж байна.

График3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл ил тод байдал\Төлөвлөгөө, тайлан, хүний нөөц, худалдан авах ажиллагаа ..




Дүгнэлт: Судалгаанд оролцсон 346 иргэдийн “Тийм” үнэлгээг 144 иргэн буюу (41.6%), “Үгүй” үнэлгээг 61 иргэн буюу (17.6%), Мэдэхгүй үнэлгээг 141 иргэн буюу (40.8%) тус бүр үнэлсэн байна.

График4: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн ойр дотны хамаатан садан, найз нөхөд ажилладаг бол түүгээр дамжуулан



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 346 иргэдийн “Тийм” үнэлгээг 6 иргэн буюу (1.2%), “Үгүй” үнэлгээг 340 иргэн буюу (98.8%) тус бүр үнэлсэн байна. Энэ нь иргэд эрх тэгш үйлчилгээг дэс дараалалттай авч байна. Тийм хэмээн хариулсан 6 иргэн каноны үйл ажиллагааны хураамжыг ойлгосон хэмээн авч үзэж байна.

График5: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ үзүүлэх



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 346 иргэдийн “Тийм” үнэлгээг 13 иргэн буюу (3.8%), “Үгүй” үнэлгээг 333 иргэн буюу (96.2%) тус бүр үнэлсэн байна. Шуурхай шударга үйлчилгээ үзүүлсэн байна.

Та төрийн байгууллагын авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх хэрэгтэй гэж үзэж байна вэ?



- ✓ Ил тод нээлттэй байх
- ✓ Мэдээлэл нээлттэй шударга зарчимд суурилах
- ✓ Төр засаг хуулиа зөв болгох хэрэгтэй
- ✓ Үнэнч шударга байх
- ✓ Хуулийн дагуу ажиллахад болно
- ✓ Шударга байдал эрх тэгш
- ✓ Шударга ёс тогтоох
- ✓ Шударга байх
- ✓ Ил тод байдал
- ✓ мэдэхгүй
- ✓ Олон ажилтантай дараалал оочиргүй бол
- ✓ Мэдэхгүй
- ✓ Ил тод байх
- ✓ цахим хүнд сурталыг багасгах
- ✓ Ил тод байх
- ✓ Үүргээ ухамсарлаж, хийх ёстой ажлаа хийж цаг тухайд нь хийх байвал авилга буурна байх



- ✓ Мэдэхгүй ээ
- ✓ Удирдлагын манлайлал албан хаагчдын манлайлал иргэдийн оролцоо чухал
- ✓ Сэтгэл зүйн сургалтанд хамруулж байх
- ✓ сургалт хийх
- ✓ дээд доодгүй л ил тод ажиллах хуульд зааснаар биелүүлж ажиллах
- ✓ Ил тод байдал, шудрага нээлттэй харилцаа, сэтгэлтэй үйлчилгээ
- ✓ Дээд төвшинд байгааг ариилгах
- ✓ Иргэдийн эрхзүйн мэдлэг чухал
- ✓ Хуулийн сурталчилгааг нийтэд байнга хүргэж байвал авилгагүйгээр түргэн шуурхай үйлчилгээг авч болдог юм байна гэдгийг ойлгоно.
- ✓ Бүх үйлчилгээ ил тод хүн бүрийг авлагыг үл тэвчих үзэлтэй болгож соён гэгээрүүлэх
- ✓ Хууль сурталчилгааг сайжруулах

Судалгааны нэгтгэл хийсэн:/Ө.Нэргүй /



Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа

